

## **ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

### **1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:**

Уг хуулийн төсөл нь 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Тус конвенцод нэгдэн орсноор татвар төлөхөөс зайлсхийх явдлын эсрэг ерөнхий дүрмийг нэвтрүүлэх, төлөөний газар, ногдол ашиг, хөрөнгийн татвартай холбоотойгоор давхар татварын гэрээ ашиглан татвараас зайлсхийх эрсдэлийг бууруулах, харилцан тохиролцох үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг олон өөрчлөлтийг Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан 26 давхар татварын гэрээнд нэвтрүүлэх боломж бүрдэх юм.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Конвенцод заасан сонголт бүхий зүйлүүдээс алийг сонгож хэрэглэхийг тусгасан болно.

### **2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:**

Монгол Улс дотоодын хууль тогтоомжийг олон улсын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн хэдий ч 1991-2003 оны хооронд бусад улс орнуудтай байгуулсан 26 хоёр талт давхар татварын гэрээнүүдийг Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдалтай тэмцэх (цаашид “BEPS” гэх) 15 үйл ажиллагааны 6, 14 дүгээр үйл ажиллагаанд нийцүүлэх шаардлагатай байгаа юм.

Тус конвенцод нэгдэн орсноор Монгол Улсын давхар татварын гэрээнүүдийг урвуулан ашиглаж татвараас зайлсхийх, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх, татварын суурийг хамгаалах чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

### **3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд олон улсын татварын чиглэлээр олон шинэлэг зарчмуудыг нэвтрүүлж хэрэгжүүлж байна. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (цаашид “ЭЗХАХБ” гэх)-аас BEPS-ийн 15 үйл ажиллагааг боловсруулан 2015 оноос нэвтрүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар дэлхийн 141 улс гишүүнээр элсэн орсон байна.

Өнгөрсөн 2022 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо ЭЗХАХБ-аас зохион байгуулсан BEPS-ийн хамрах хүрээний 14 дэх уулзалтын үеэр “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-д гарын үсэг зурснаар нь Монгол Улс нь тус конвенцод нэгдэж орсон 100 дахь улс болсон билээ.

#### **4. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.9-д олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно гэж заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй болно.

#### **5. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:**

Монгол Улс нь 2017 оны 12 дугаар сард BEPS-ийн хамрах хүрээнд албан ёсны гишүүнээр нэгдэж орсон бөгөөд үүнтэй холбогдуулан олон улсын татварын чиглэлээр үүсээд буй шинэлэг дүрмүүдийг дотоодын хуульд тусгах, улмаар давхар татварын хэлэлцээрт хамаарах шаардлагуудыг хангаж ажиллах үүргийг хүлээж байна.

BEPS-ийн 15 үйл ажиллагаа нь дотоодын татварын хууль, эрх зүйн орчин, хэрэгжилт болон давхар татварын гэрээтэй холбоотой асуудлуудыг багтааж байна.

Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд олон улсын татварын асуудлаар улс орнуудад гарч буй шинэлэг зарчмуудыг нэвтрүүлэх чиглэлээр BEPS-ийн үйл ажиллагааны холбогдох зарчмуудыг Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдэд тусгаж, улмаар Монгол Улсын Их Хурал 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр эдгээр хуулиудыг баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Цаашид манай улс BEPS-ийн 6, 7 болон 14 дүгээр үйл ажиллагаанд заасан давхар татварын гэрээнд холбогдох шаардлагуудыг бусад улсуудтай байгуулсан давхар татварын гэрээнд тусгаж, гишүүний хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлага тулгараад байна. BEPS-ийн 6 дугаар үйл ажиллагаа нь заавал авч хэрэгжүүлэх шаардлагатай /minimum standard/ стандартад багтдаг. Энэхүү үйл ажиллагаа нь гуравдагч улсын хөрөнгө оруулагч давхар татварын гэрээг урвуулан ашиглах /treaty shopping/ буюу гэрээний сүлжээ дамжуулан татвараас зайлсхийх асуудлыг хязгаарлах зорилготой юм. Түүнчлэн, BEPS-ийн 14 дугаар үйл ажиллагаанд давхар татварын гэрээний дагуу оршин суугч этгээд нь хэлэлцэн тохирогч аль нэг улсын татварын алба хэлэлцээрийг буруу хэрэглэсэн, татварын давхардал бий болсон гэж үзсэн тохиолдолд эрх бүхий этгээдэд уг асуудлаар хандах боломжийг нээх, хандсан тохиолдолд эрх бүхий этгээдүүд шийдвэрлэхтэй холбогдох асуудлуудыг тусгасан байдаг. Энэхүү асуудлыг хэлэлцээрийн Харилцан тохиролцох журмаар /Mutual agreement procedure/ зохицуулдаг бөгөөд давхар татварын гэрээнд зайлшгүй тусгах ёстой заалтууд, үүнийг хэрэгжүүлэх дотоодын журам, механизм болон статистиктай холбоотой стандартуудыг тусгасан байдаг.

BEPS-ийн давхар татварын гэрээтэй холбоотой заавал биелүүлэх шаардлагатай 6 болон 14 дугаар үйл ажиллагаанд туссан өөрчлөлтүүдийг олон улсад нэвтрүүлэхэд 1,000 гаруй давхар татварын гэрээнд хоёр талт хэлэлцээрийн замаар өөрчлөлт оруулах шаардлага байсан нь BEPS-ийн гишүүн улсуудад цаг хугацааны хувьд хүндрэлтэй, зардал ихтэй зэргийг харгалзаж ЭЗХАХБ-аас BEPS-ийн 15 дугаар үйл ажиллагаанд туссан Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенцод нэгдэж орох замаар эдгээр өөрчлөлтийг түргэн хугацаанд нэвтрүүлэх боломжийг бий болгосон.

Иймд BEPS-ийн 15 дугаар үйл ажиллагаанд заасан “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-д нэгдэн орж татварын гэрээг урвуулан ашиглахаас сэргийлэх, төлөөний газар, ногдол ашиг, хөрөнгийн татвартай холбоотой хийдлийг арилгах, харилцан тохиролцох үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг зохицуулалтуудыг бусад улсуудтай байгуулсан давхар татварын гэрээнд тусгах замаар Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод татвар ногдуулах харилцааг бэхжүүлэх, татварын суурийг хамгаалах нь манай улсын эрх ашигт бүрэн нийцэж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газраас гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор гадаад улс орнуудтай давхар татвар ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хоёр талын хэлэлцээрийг 1991-2004 онуудад идэвхтэйгээр байгуулсан. Өнгөрсөн хугацаанд манай улс нийт 35 улстай давхар татвар ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийг үзэглэснээс 5 гэрээ соёрхон батлагдаагүй өнөөг хүрч, 4 улстай байгуулсан хэлэлцээрийг цуцалж, 26 хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Монгол Улсын давхар татварын гэрээний сүлжээ болон гэрээ байгуулсан улсуудын уг конвенцод нэгдэж орсон байдлыг дор дурдсан хүснэгтээр харуулав.

*Хүснэгт. МУ-ын давхар татварын гэрээний сүлжээ болон гэрээ байгуулсан улсуудын олон талт конвенцод нэгдэж орсон байдал*

Д/д	Улсын нэрс	Үзэглэсэн	Гарын үсэг зурсан	Үйлчилж байгаа	MLI Үзэглэсэн огноо/статус	MLI хүчин төгөлдөр мөрдөгдөх огноо	Монгол Улстай байгуулсан давхар татварын хэлэлцээрийг хамрагдах татварын хэлэлцээрт оруулсан эсэх
1	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	1991.07.29	1991.08.26	1993.01.01	2017.06.07		Тийм
2	Бүгд Найрамдах Солонгос Улс	1992.02.27	1992.04.17	1993.06.06	2017.06.07	2020.09.07	Тийм
3	Холбооны Бүгд	1992.05.18	1994.08.22	1997.01.01	2017.06.07	2021.01.07	Үгүй

	Найрамдах Герман Улс						
4	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	1994.12.24	1994.02.22	1996.03.29	2017.06.07	2021.01.10	Тийм
5	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	1996.02.29	1996.05.09	1997.01.01	Нэгдэж ороогүй		Тийм
6	Оросын Холбооны Улс	1993.05.25	1995.04.05	1997.05.22	2017.06.07	2019.10.01	Тийм
7	Бүгд Найрамдах Турк Улс	1993.06.26	1995.09.12	1996.12.30	2017.06.07		Тийм
8	Бүгд Найрамдах Франц Улс	1994.01.31	1996.03.18	1998.12.01	2017.06.07	2019.01.01	Тийм
9	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс	1994.05.13	1996.04.23	1996.12.04	2017.06.07	2018.10.01	Тийм
10	Бүгд Найрамдах Чех Улс	1996.07.10	1997.02.27	1998.06.22	2017.06.07	2020.09.01	Тийм
11	Бүгд Найрамдах Унгар Улс	1994.05.20	1994.09.13	1998.04.14	2017.06.07	2021.03.25	Тийм
12	Бельгийн Хаант Улс	1994.07.01	1995.09.26	2000.03.30	2017.06.07	2019.06.26	Тийм
13	Бүгд Найрамдах Польш Улс	1995.02.02	1997.04.18	2001.07.21	2017.06.07	2018.01.23	Тийм
14	Малайз Улс	1995.07.23	1995.07.27	1996.11.07	2018.01.24	2021.02.18	Тийм
15	Бүгд Найрамдах Казахстан Улс	1995.09.22	1998.03.12	1999.12.02	2018.06.25	2020.10.01	Тийм
16	Бүгд Найрамдах Индонез Улс	1995.10.21	1996.07.02	1998.01.01	2017.06.07	2020.04.28	Үгүй
17	Бүгд Найрамдах Болгар Улс	1996.11.25	2000.02.28	2003.02.17	2017.06.07		Тийм
18	Украин Улс	1997.03.26	2002.07.01	2006.11.03	2018.07.23	2019.08.08	Тийм
19	Швейцарын Холбооны Улс	1998.06.24	1999.09.20	2002.01.01	2017.06.07	2019.12.01	Үгүй
20	Бүгд Найрамдах Беларусь Улс	1998.04.23	2001.05.28	2002.01.01	Нэгдэж ороогүй		Тийм
21	Бүгд Найрамдах Киргиз Улс	1999.06.20	1999.12.04	2002.01.01	Нэгдэж ороогүй		Тийм
22	Канад Улс	2000.04.07	2002.05.27	2002.12.20	2017.06.07	2019.08.29	Тийм
23	Бүгд	2001.08.16	2002.10.10	2004.10.22	2017.06.07	2018.12.21	Тийм

	Найрамдах Сингапур Улс						
24	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	2002.10.03	2004.05.03	2005.01.01	Нэгдэж ороогүй		Тийм
25	Бүгд Найрамдах Австри Улс	2003.07.03	2004.10.01	2005.01.01	2017.06.07	2018.07.01	Үгүй
26	Бүгд Найрамдах Итали Улс		2003.09.11	N/A	2017.06.07		Тийм

Одоогийн байдлаар тус конвенцод нэгдэж орсноор Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан 18 давхар татварын гэрээнд дээр дурдсан өөрчлөлтүүдийг оруулах боломжтой болох юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

### 1. Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:

Уг хуулийн төсөл нь 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Тус конвенцод нэгдэн орсноор татвар төлөхөөс зайлсхийх явдлын эсрэг ерөнхий дүрмийг нэвтрүүлэх, төлөөний газар, ногдол ашиг, хөрөнгийн татвартай холбоотойгоор давхар татварын гэрээ ашиглан татвараас зайлсхийх эрсдэлийг бууруулах, харилцан тохиролцох үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг олон өөрчлөлтийг Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан 26 давхар татварын гэрээнд нэвтрүүлэх боломж бүрдэх юм.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Конвенцод заасан сонголт бүхий зүйлүүдээс алийг сонгож хэрэглэхийг тусгасан болно:

1. Конвенцын 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн а)-д заасныг үндэслэн Монгол Улс өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд 3 дугаар зүйл (Ил тод этгээдүүд)-ийг бүхэлд нь хэрэглэхгүй байхаар тусгасан. Конвенцын 3 дугаар зүйл нь хэлэлцэн тохирогч улсуудын татварын хууль хоорондын зөрүүг ашиглан татвараас зайлсхийх явдлын эсрэг асуудлыг зохицуулдаг.

Харин Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг” ойлгохоор буюу өргөн хүрээгээр тодорхойлсон тул Монгол Улсаас эх үүсвэртэй болон Монгол Улсад орлого олсон аливаа хуулийн этгээдийг татварт хамруулах асуудлыг давхар татварын гэрээний хүрээнд хязгаарлахгүй юм. Иймд, конвенцын 3 дугаар зүйлд заасныг өөрийн хамрагдах татварын хэлэлцээрт хэрэглэх шаардлагагүй юм.

2. Конвенцын 5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улс өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд 5 дугаар зүйлийг бүхэлд нь хэрэглэхгүй

байхаар сонгосон. Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан давхар татварын гэрээнүүд буюу конвенцын хамрагдах татварын гэрээнд Монгол Улс нь хэлэлцэн тохирогч нөгөө улсад олсон орлогыг татвараас хөнгөлөх байдлаар татварын давхардлыг арилгахаар тусгасан байдаг тул конвенцын 5 дугаар зүйлд заасныг өөрийн хамрагдах гэрээнүүдэд хэрэглэх шаардлагагүй юм.

3. Конвенцын 6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улс 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "Татварын асуудлаарх Талуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх болон эдийн засгийн харилцааг цаашид үргэлжлүүлэн хөгжүүлэхийг зорьж," гэснийг өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд хэрэглэхээр сонгосон болно. Энэ нь татвараас зайлсхийх явдлын эсрэг хэлэлцэн тохирогч улсуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх агуулгатай тул өөрийн хамрагдах татварын гэрээнд хэрэглэхээр тусгалаа.

4. Конвенцын 7 дугаар зүйлийн 17 дахь хэсгийн b), d)-д заасныг үндэслэн Монгол Улс 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд хэрэглэхээр сонгосон. Конвенцын 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд хэрэглэхээр сонгосноор татвараас зайлсхийх үндсэн зорилготой ажил, гүйлгээнд давхар татварын гэрээний дагуу давуу тал олгох буюу бага хэмжээгээр татвар ногдуулах, татвараас хөнгөлөх асуудлыг хязгаарлах боломжтой болох юм. Түүнчлэн, Монгол Улстай давхар татварын гэрээ байгуулсан бусад дийлэнх улсууд энэ зүйлийг хамрагдах татварын гэрээнд хэрэглэхээр заасан байна.

5. Конвенцын 9 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улс 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд хэрэглэхээр сонгосон. Конвенцын 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг нь хэлэлцэн тохирогч нэг улсад байрладаг үл хөдлөх хөрөнгийг хувьцаа эсхүл хувь оролцоогоо борлуулах замаар шилжүүлсэн тохиолдолд давхар татварын гэрээний дагуу олгох хөнгөлөлтөд тодорхой шаардлагыг тусгах зохицуулалттай. Энэ зүйлийг өөрийн хамрагдах татварын хэлэлцээрт хэрэглэхээр сонгох нь Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлогод татвар ногдуулах эрхээ хамгаалахад эерэг нөлөөтэй гэж үзсэн болно.

6. Конвенцын 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улс 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Хувилбар А-д заасныг өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд хэрэглэхээр сонгосон. Конвенцын 13 дугаар зүйл нь тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийхээс сэргийлж, олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор Хувилбар А-д дурдсан тохиолдлуудыг төлөөний газар гэдэг нэр томъёонд хамааруулахгүй байхаар сонголоо.

7. Конвенцын 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн а)-д заасныг үндэслэн Монгол Улс 17 дугаар зүйлийн 2-т заасныг агуулсан хамрагдах татварын гэрээнүүдэд 17 дугаар зүйлийг бүхэлд нь хэрэглэхгүй байхаар тусгасан. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн ашигт Хэлэлцэн тохирогч улсад ногдуулсан татварын хэмжээнд зохих тохируулга хийх Хэлэлцэн тохирогч улсын үүргийн тухай зохицуулалтын оронд 17

дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэх шаардлагагүй гэж үзэн тус зүйлийг бүхэлд нь хэрэглэхгүй байхаар хуулийн төсөлд тусгалаа.

8. Конвенцын 18 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улс 6 дугаар бүлгийг бүхэлд нь хэрэглэхгүй байхаар сонгосон болно. Конвенцын 18 дугаар зүйлд татварын асуудлаар аливаа шийдэгдээгүй маргааныг олон улсын арбитрын дагуу шийдвэрлэх харилцааг зохицуулдаг бөгөөд үүнийг тус Конвенцод нэгдэн орсон дэлхийн хөгжиж буй улсуудын дийлэнх нь хэрэглэхээр сонгоогүй байна. Улмаар дотоодын хууль тогтоомж болон давхар татварын гэрээний харилцан тохиролцох журмын дагуу аливаа татварын маргааныг шийдвэрлэх боломжтой гэж үзэн тус зүйлийг хэрэглэхгүй байхаар хуулийн төсөлд тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР